



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.УЯНГА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСТАЛЫН
ӨӨРЧЛӨЛТНИЙН САЙД

Засгийн газрын байр 12, Барилгачдын талбай 3,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.mecc.gov.mn

2026.08.03 № 01/4668
танай -ны № -т

Асуулгын хариу

Танаас ирүүлсэн 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 38 дугаартай байгаль орчны үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олголтын талаар ирүүлсэн асуулгатай танилцаж дараах мэдээллийг хүргүүлж байна.

1. Тус яамнаас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгохдоо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.1.1.7, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтыг тус тус баримтлан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан эсэхэд мөн хуулийн 12.7-д заасны дагуу өргөдөл болон тайлан, байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбогдсон бусад мэдээллийг мэргэжлийн зөвлөл хянан үзэж хуулийн 12.5 болон 12.8-д заасан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийн гурван жилийн хугацаагаар шинээр олгох, хугацааг сунгах эсэх талаар дүгнэлт гарган ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар Байгаль орчны мэдээллийн сан (eis.mn)-д уул уурхай, дэд бүтэц, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий 89 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байна.

Эдгээр байгууллагад байгаль орчны салбарын нийт 1,099 мэргэжилтэн ажиллаж байгаагаас 385 нь үндсэн ажилтан, 714 нь гэрээт мэргэжилтэн байна.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/200 дугаар тушаалаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд чадавхын үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулж Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон холбогдох эрх зүйн актад заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагуудын чадавх, хүний нөөц, баримт бичгийн бүрдэлд үнэлгээ хийсэн.

Ажлын хэсгийн дүнгээс харахад байгаль орчны үнэлгээний мэргэжлийн байгууллагад ажиллаж буй ажилтнуудын ажлын туршлага, хүний нөөцийн чадавх хангалтгүй байсан бөгөөд ихэнх байгууллага 2–3 үндсэн ажилтантай, нэмэлтээр 3–6 хүнийг тухай бүр хөдөлмөрийн гэрээгээр түр ажиллуулан үйл ажиллагаа явуулж байгаа нь тогтоогдсон.

Мөн чадавхын үнэлгээнд хамрагдсан 128 мэргэжлийн байгууллагыг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэхэд 33–59 оноо авсан 28 байгууллага, 60–79 оноо авсан 75 байгууллага, 80–100 хүртэл оноо авсан 24 байгууллага тус тус үнэлэгдэж нийт хамрагдсан байгууллагын 21.8 хувь нь маш муу, 58.6 хувь нь хангалтгүй, 18.7 хувь нь хангалттай үнэлгээ авсан байна.

Ажлын хэсгээс 33–59 оноо авсан 28 мэргэжлийн байгууллагад зөрчил арилгах хугацаатай албан шаардлага, 60–79 оноо авсан 75 мэргэжлийн байгууллагад анхааруулга, сануулах албан бичгийг тус тус хүргүүлсэн болно.

Түүнчлэн Байгаль орчны мэдээллийн сангийн бүртгэлд байсан 361 мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн эрхийн хугацаа дууссан, хуульд заасан шаардлага хангаагүй, зөвшөөрлийн хугацааг сунгах боломжгүй болсон 190 мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй хүчингүй болгосон байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд хөрс, ус, агаар, хог хаягдал болон бусад орчны дээж, сорьцод шаардлагатай шинжилгээ, лабораторийн судалгааг тухайн байгууллагын өөрийн лаборатори болон итгэмжлэгдсэн мэргэжлийн 27 лабораториор гүйцэтгүүлж, шинжилгээний үр дүнд үндэслэн үнэлгээний дүгнэлтийг боловсруулан ажиллаж байна. /хавсралт 1/

3. Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасныг үндэслэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/835 дугаар тушаалаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд хянан магадлагаа хийх ажлын хэсгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу анх удаа байгуулж, нэр бүхийн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд хянан магадлагаа хийсэн.

Тухайлбал, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Эмээлтийн суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулж буй “Торгон шир бэлтгэл” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Малын арьс, нэхийгээс үсийг гэмтээлгүй хуурай технологийн аргаар салгах үйлдвэр байгуулах” төслийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, “Лагуна Оюу” ХХК-ийн боловсруулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд хянан магадлагаа хийж, үйлдвэрлэлийн технологийн орц, найрлага нь төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан үзүүлэлтээс зөрүүтэй байсан, үйлдвэрлэлийн технологийн процесст энзим ашиглаагүй, ашиглаж буй технологи нь Монгол Улсын MNS 5480 “Арьс, шир, үслэг боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага” стандарт, мөн олон улсын EU BAT, IUE болон LWG-ийн *Hair-save unhairing* (үсийг гэмтээлгүй салгах технологи)-ийн шаардлагыг бүрэн хангаагүй зөрчил, дутагдал илэрсэн.

Дээрх нөхцөл байдлыг үндэслэн Технологи дамжуулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.5 дахь хэсэгт заасны дагуу ашиглаж буй технологид холбогдох эрх бүхий байгууллагаар технологийн түвшний үнэлгээ хийлгэж, уг үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, түүнчлэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд нэмэлт, тодотгол боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах шаардлагатай гэж ажлын хэсгээс дүгнэлт гарган зөрчил, дутагдлыг бүрэн арилгаж, хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангуулах хүртэл төслийн үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болно.

4. Уул уурхай болон томоохон бүтээн байгуулалтын төслүүдийн байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд улсын хэмжээд хяналт шалгалт явуулж 2026 оны эхний хагас жилийн байдлаар 820 объектод хяналт шалгалт явуулж байгаль орчны эсрэг 2280 зөрчил, дутагдал илрүүлж зөрчлийг арилгуулах 156 албан шаардлага, албан даалгавар, 40 улсын байцаагчийн акт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд 54 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр болон хэсэгчлэн зогсоож 175 гомдол мэдээллийг Прокурорын бүртгэлд бүртгүүлэн хялбаршуулсан журмаар 82, зөрчлийн 29 хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, гэмт хэргийн шинжтэй 49 үйлдлийг илрүүлэн Экологийн цагдаагийн албанд шилжүүлээд байна.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 10 дугаар албан даалгавар, Монгол Улсын Шадар

оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 10 дугаар албан даалгавар, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр хуралдаанаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврыг улсын хэмжээнд ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд хамтарсан хяналт шалгалтын хүрээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний чиглэлээр Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлд заасныг зөрчсөн үйлдэлд хялбаршуулсан журмаар 46, зөрчлийн 7 хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 8 аж ахуйн нэгжид эрх хязгаарлах арга хэмжээг авч ажилласан болно.

5. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавьж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн чанар, үнэлгээний арга зүй, мэргэжлийн төвшинд тогтмол үнэлгээ хийж ажиллаж байна.

Мөн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэх явцад тайлангийн агуулга хангалтгүй, мэдээлэл дутуу, эсхүл хууль тогтоомж, арга зүйн шаардлага хангаагүй гэж дүгнэгдсэн тохиолдолд тухайн эрх бүхий байгууллагад албан ёсны сануулга өгч байгаа бөгөөд хэрэв тухайн мэргэжлийн байгууллага удаа дараалан сануулга авсан бол тусгай зөвшөөрлийг сунгахаас татгалзах, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэлх арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлж ажиллаж байна.

"Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо" төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус холбоонд одоогийн байдлаар 74 гишүүн байгууллага нэгдэн орсон байна.

Тус холбоо нь салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг дэмжих, мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчны үнэлгээний чанарыг сайжруулах, гишүүн байгууллагуудад ажиллаж буй шинжээчдийн мэргэжлийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Харин БОУАӨЯ-аас байгаль орчны үнэлгээний тогтолцоог олон улсын сайн туршлага, жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, үнэлгээний байгууллагуудын хараат бус, хариуцлагатай үйл ажиллагааг бэхжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, байгаль орчны үнэлгээний чанар болон хариуцлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр эрх зүйн орчныг шинэчлэх бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

6. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, мөн Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.2.13-т "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулж, бизнес дэх байгаль орчны үнэлгээний ангиллыг цөөрүүлж, төрийн оролцоог бууруулах" зорилтыг тусгасан.

Энэхүү бодлогын хүрээнд "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулснаар бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны үнэлгээ хийх ангилал, зохицуулалтыг оновчтой болгож, давхардал, хүндрэлтэй зохицуулалтыг бууруулан үйл ажиллагааг хялбаршуулсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд төрийн байгууллага санал өгөх, хянах, батлах хугацааг хуульчилж, шийдвэр гаргах үйл явцыг илүү тодорхой, шуурхай болгосон, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ боловсруулахдаа нийгмийн нөлөөллийн үнэлгээг хамтатган хийх эрх зүйн үндсийг бүрдүүлснээр үнэлгээний агуулгыг олон улсын жишиг, стандарттай нийцүүлсэн, байгаль орчны үнэлгээний тогтолцооны цахим шилжилт, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль-тай уялдуулж, Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т заасан иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлээд байна.

Мөн мэргэжлийн зөвлөлийн хурлаар батлагдсан байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангуудыг байгаль орчны мэдээллийн eic.mn цахим санд олон нийтэд нээлттэй байршуулж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Түүнчлэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг license.mn зөвшөөрлийн цахим системд бүрэн шилжүүлсэн нь тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авах, шийдвэрлэх хугацааг богиносгох, төрийн үйлчилгээний хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэх, хүний оролцоог бууруулах нөхцөл бүрдүүлээд байна.



Байгаль орчин, уур амьсгалын
өөрчлөлтийн яам
Сайд
Ц.Сандаг-Очир
2026.08.03 16:33

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд хөрс, ус, агаар, хаягдал болон бусад орчны дээж, сорьцод шаардлагатай шинжилгээ, лабораторийн судалгааг тухайн байгууллагын өөрийн лаборатори болон итгэмжлэгдсэн мэргэжлийн лабораториор гүйцэтгүүлж, шинжилгээний үр дүнд үндэслэн үнэлгээний дүгнэлтийг боловсруулдаг.

Энэ хүрээнд дараах итгэмжлэгдсэн лаборатори, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн лаборатори;
- АЛС ХХК;
- Грийн Лаб;
- Ханлаб ХХК;
- Нарт ШУҮН Консалтинг;
- Инженер Геодези ХХК;
- ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн;
- Хөдөө аж ахуйн их сургуулийн Хөрс, усны итгэмжлэгдсэн лаборатори;
- ШУТИС-ийн лаборатори;
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын Төв лаборатори;
- Ус сувгийн удирдах газрын Усны төв лаборатори;
- ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэн;
- Эс-Жи-Эс Монголиа ХХК;
- МУИС-ийн Химийн лаборатори;
- Монгол Ус ТӨҮГ-ийн Усны төв лаборатори;
- Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори;
- Классик Лэнд;
- Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори;
- Инно Хими лаборатори;
- Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн лаборатори;
- МУИС-ийн Цөмийн физикийн судалгааны төвийн лаборатори;
- Ус, цаг уур, орчны шинжилгээний газар;
- TRUE LLC;
- Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ;
- Геоаналитик ХХК-ийн лаборатори;
- Аймгуудын Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн лабораториуд;
- МУИС-ийн лаборатори.

Дээрх итгэмжлэгдсэн лабораториудаар хөрс, ус, агаар, хаягдал болон хүрээлэн буй орчны бусад бүрэлдэхүүн хэсгээс авсан дээж, сорьцод шинжилгээ хийлгэж, гарсан үр дүнг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, дүгнэлтийг боловсруулахад ашиглаж байна.